



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Авто үйлчилгээний ангилал тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Автотээврийн тухай хуулийн 19² дугаар зүйл, Зам, тээврийн сайдын 2016 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 31 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн тээврийн газрын дүрмийн 2.4, 2.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд ангилал тогтоох орон тооны бус “Зөвлөл”-ийн хурлын шийдвэрийн дагуу авто үйлчилгээний ангиллын гэрчилгээ олгох аж ахуйн нэгжүүдийг хавсралт ёсоор баталсугай.
2. Ангиллын гэрчилгээ олгогдсон аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдох хүрээний ажил үйлчилгээний гэрээ байгуулахыг Тээвэр, логистикийн хэлтэс /Г.Баасан/-т даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Доржпалам/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР

Нийслэлийн Тээврийн газрын даргын
2017 оны 28 дугаар сарын 11-ний өдрийн
А/29 дугаар тушаалын хавсралт



АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЛЛЫН ГЭРЧИЛГЭЭГ ОЛГОХ
АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ

№	Ажил үйлчилгээний төрөл	Ангилал	Гэрчилгээ олгох аж ахуйн нэгж, байгууллага
"А" хүрээний ажил үйлчилгээ: Автомашин хөдөлгөөний аюулгүй байдлыг шууд хангахтай холбоотой агрегат, зангилаа, механизм /явах анги, тоормос, гэрэлтүүлэг, дохиоллын систем гэх мэт/-ын иж бүрэн засвар, үйлчилгээ, оношлогоо хийх			
1.	Хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой үндсэн агрегат, механизм, зангилааны засвар үйлчилгээг төрөлжсөн хэлбэрээр хийх	А2	"Таван богд" ХХК
			"Мүгэн" ХХК
			"Моннис моторс" ХХК
"С" хүрээний ажил үйлчилгээ: Автомашин, сэлбэг худалдах, авто бирж, авто техникийн зах ажиллуулах, сэлбэг хэрэгсэл, тосолгооны болон ашиглалтын бусад материалаар хангах, цэнэглэх, автозогсоолын үйлчилгээ эрхлэх			
2.	Автомашин, сэлбэг хэрэгсэл, тослох материалыг үйлдвэрлэгчээс шууд бөөнөөр нийлүүлдэг дистрибьютерын үйлчилгээ үзүүлэх	С1	"Таван богд" ХХК
			"Моннис моторс" ХХК
3.	Сэлбэг хэрэгсэл, тосолгооны болон ашиглалтын бусад материалын жижиглэн худалдаа, авто зогсоол болон бусад худалдаа үйлчилгээ эрхлэх	С3	"Мүгэн" ХХК